

НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР
2020.10.13-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ШУУРХАЙ ХУРЛААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ
2020.10.20

№	Товч агуулга	Биелэлт
1	“Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эрдэм шинжилгээний хурал”-д эрдэмтэн судлаачдыг оролцох боломжоор хангах	<p>“Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эрдэм шинжилгээний хурал”-д Нийслэлийн Өргөө амаржих газрын эмч нарын АУ-ны магистр, докторын ажлын 2 бүтээлээр оролцох бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Монголчуудын дунд тохиолдож буй ургийн ба тагнайн төрөлхийн сэтэрхийтэй methylenetetrahydrofolate reductase (MTHFR) нярайн генийн полиморфизмын A1298C-ийн хоорондын хамаарал (Судлаач: Э.Лхагва-Очир, Х.Баярсайхан, Р.Батжаргал, Т.Нямжав, Т.Мөнхзул, А.Мөнхбилгүүн, Т.Ганжигүүр, Т.Эрхэмбаатар НӨАГ) 2. Нярайн зүрхний төрөлхийн гажгийг эрт илрүүлэх пульсоксиметрийн скрининг судалгаа (Судлаач: Б.Өлзийхишиг, НӨАГ, Удирдагч: З.Гэрэлмаа АУ-ы доктор, профессор, Т.Болормаа АУ-ы доктор)
2	Сайн туршлага-2020” арга хэмжээнд оролцох шилдэг технологи, шинэ бүтээлч ажлуудын талаарх материалыг бэлдэх	Нийслэлийн Эрүүл мэндийн газраас 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулагдах гэж буй “Сайн туршлага-2020” арга хэмжээний талаар мэдээлэл өгөх хуралд 10 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн Өргөө амаржих газраас холбогдох 3 ажилтан оролцож дэлгэрэнгүй мэдээлэл авсан. Тус арга хэмжээнд манай амаржих газраас оролцох бүтээлүүдийн материалыг хүлээж авах, шалгаруулах үйл ажиллагааг 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж, шилдэг технологи, шинэ бүтээлч ажлуудын талаарх материалыг бэлдэх ажлын бэлтгэлийг хангаж НЭМГ-ын хариуцсан мэргэжилтэнд нэгтгэж заасан хугацаанд материалаа хүргүүлэх болно.
3	ТТТӨ-нөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг эрчимжүүлэх	Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”-г батлуулж төлөвлөгөөний дагуу томуу томуу тест өвчний шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчдийг хүлээн авах 2 өрөө гарган ажиллаж байна. Тус өрөөнүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ хэвийн явагдах ба тухайн өрөө рүү нэвтрэхдээ эмч, эмнэлгийн ажилтан нь нэг удаагийн хэрэгсэл, маскыг хэрэглэн дотогш нэвтрэхээр зохион байгуулсан.
4	Бүх байгууллагууд халдвар хамгааллын дэглэм, коронавируст “Ковид-19” халдварын үеийн дэглэмээ чандлан баримталж ажиллах	Шинэ коронавирусын халдварын сэжигтэй/батлагдсан үйлчлүүлэгчийг шаардлагатай үед хүлээн авч эмнэлгийн тусламж үзүүлэх 30 ортой хэсгийг бэлдэж, тухайн үед ашиглах төлөвлөгөөг гарын авлага хэлбэрээр боловсруулан гаргасан. Тус гарын авлагад ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэний нэрс, шаардлагатай нөөц нүүлгэн шилжүүлэлт зэргийг тусгасан болно.
5	ЭМЯ-наас чиглэл ирэх хүртэл томуугийн дархлаажуулалтыг зорилтот бүлгийнхэнд үргэлжүүлэн хийх	НӨАГ-ын хэмжээнд нийт 380 томуугийн вакцин ирсэн. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг 100% вакцинд хамруулсан.